11	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	16,752,883,335.80	412,355,075.54	30,629,177,287.18	47,794,415,698.52
12	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,533,958,150.52	(165,114,902.15)	(1,352,875,787.51)	15,967,460.86
13	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	18,286,841,486.32	247,240,173.39	29,276,301,499.67	47,810,383,159.38
14	1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(91,996.00)	-	(91,996.00)
15	1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	(24,864.00)	-	(24,864.00)
19	1.7 Тайлант үеийн үр дүн	-	-	8,599,309,697.79	8,599,309,697.79
20	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	18,286,841,486.32	247,123,313.39	37,875,611,197.46	56,409,575,997.17

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	20,533,717,800	20,773,462,743
11	3.1.01.1.1 Татварын орлого	18,870,214,000	19,350,723,031
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	17,254,031,000	17,903,560,141
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	17,254,031,000	17,903,560,141
110001	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	13,662,000,000	14,476,809,416
110002	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	733,700,000	715,712,599
110003	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	1,626,135,500	1,380,316,067
110004	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	499,160,400	566,050,898
110008	3.1.01.1.1.1.1.07 Шууд бус орлого	733,035,100	764,671,162
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	482,464,100	526,769,147
113001	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	415,264,100	414,999,947
113002	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	12,200,000	13,110,000
113004	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	55,000,000	98,659,200
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	1,133,718,900	920,393,743

1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	509,066,200	536,469,453
118001	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	27,316,200	16,266,200
118006	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	15,000,000	32,118,840
118009	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	466,750,000	488,084,413
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	596,052,700	355,721,097
118101	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	596,052,700	355,721,097
1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	28,600,000	28,203,193
118201	3.1.01.1.1.8.3.01 Ойн нөөц ашигласны төлбөр	4,600,000	7,141,523
118203	3.1.01.1.1.8.3.03 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	24,000,000	21,061,670
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	1,663,503,800	1,422,739,712
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	643,000,000	406,892,601
120003	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	243,000,000	149,234,518
120004	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	400,000,000	236,460,315
120010	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	0	21,107,600
120009	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	0	90,168
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,020,503,800	1,015,847,111
123002	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	1,020,503,800	1,015,847,111
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,432,138,600	22,494,348,063
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	21,527,738,900	21,196,513,680
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,381,900,200	10,099,571,590
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,743,286,000	2,702,502,620
210101	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	2,288,190,500	1,276,436,711
210102	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	0	901,203,305
210103	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	169,464,000	206,864,000
210104	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	102,753,300	154,506,434
210105	3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс	182,878,200	163,492,171
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	344,814,700	336,806,915
210201	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	235,178,100	227,093,868
210202	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	27,409,200	27,524,937
210203	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	13,704,600	13,845,140
210204	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	13,704,600	13,524,772
210205	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	54,818,200	54,818,198
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,979,750,500	3,887,148,067
210301	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	651,446,600	458,977,629
210302	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	2,693,463,300	2,974,134,656
210303	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	634,840,600	454,035,782
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	183,746,800	137,513,522
210401	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	21,932,500	17,848,800
210402	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	108,971,900	86,182,728
210403	3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,557,400	11,742,304
210405	3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,700,000	1,500,000
210406	3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	33,585,000	20,239,690

2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	299,634,100	288,349,573
210601	3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл	66,349,900	65,886,250
210604	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	233,284,200	222,463,323
2107	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	67,113,100	39,252,900
210702	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт	67,113,100	39,252,900
2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,204,870,500	2,195,750,986
210801	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,169,337,100	2,166,966,954
210802	3.1.01.2.1.1.8.02 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	619,200	547,200
210803	3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ	4,431,000	1,973,310
210804	3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар	391,000	270,512
210805	3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000	110,000
210806	3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,256,500	4,650,000
210807	3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр	21,714,700	21,233,010
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	558,684,500	512,247,007
210901	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	361,065,500	343,684,772
210902	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	197,619,000	168,562,235
212	3.1.01.2.1.3 ТАТААС	73,380,000	73,300,000
2122	3.1.01.2.1.3.2 Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	73,380,000	73,300,000
212201	3.1.01.2.1.3.2.01 Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	73,380,000	73,300,000
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,072,458,700	11,023,642,090
2131	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	10,907,341,200	10,907,341,200
213101	3.1.01.2.1.4.1.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	10,907,341,200	10,907,341,200
2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	165,117,500	116,300,890
213205	3.1.01.2.1.4.2.04 Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	58,736,000	34,992,000
213207	3.1.01.2.1.4.2.06 Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,859,100	20,975,462
213208	3.1.01.2.1.4.2.07 Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,022,400	6,022,428
213209	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	77,500,000	54,311,000
22	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,504,399,700	1,237,834,384
223001	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	1,504,399,700	1,237,834,384
23	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	400,000,000	60,000,000
230001	3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл	400,000,000	60,000,000
8	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	2,898,420,800	-1,720,885,320
9	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-2,898,420,800	1,720,885,320
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-2,898,420,800	1,720,885,320
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	4,309,355,407
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	2,588,470,087
6	6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	152	150
61	6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
610001	6.1.01 Төсвийн байгууллага	2	2
62	6.2 АЖИЛЛАГСДЫН ТОО	75	74
620001	6.2.01 Удирдах ажилтан	16	16
620002	6.2.02 Гүйцэтгэх ажилтан	34	33

620003	6.2.03 Үйлчлэх ажилтан	8	8
620004	6.2.04 Гэрээт ажилтан	17	17
65	6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	75	74
650001	6.5.01 Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	28	29
650009	6.5.09 Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	28	26
650010	6.5.10 Гэрээт ажилтан	4	4
650011	6.5.11 Улс төрийн албан хаагч (УТ)	15	15

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	27,065,746.00
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,065,746.00
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	27,065,746.00
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	27,065,746.00
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	27,065,746.00
350013	1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	25,065,746.00
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,975,578.00
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	26,975,578.00
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,575,578.00
2101	1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,710,100.00
210101	1.1.1.2.1.1.1.1 Үндсэн цалин	358,005.35
210102	1.1.1.2.1.1.1.2 Нэмэгдэл	1,352,094.65
2102	1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	197,225.00
210201	1.1.1.2.1.1.2.1 Тэтгэврийн даатгал	197,225.00
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	13,668,253.00
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	6,497,253.00
210406	1.1.1.2.1.1.4.6 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,171,000.00
2106	1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00
210604	1.1.1.2.1.1.6.4 Урсгал засвар	8,000,000.00
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00
210902	1.1.1.2.1.1.9.2 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00
213	1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,400,000.00

2132	1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	1,400,000.00
213209	1.1.1.2.1.4.2.8 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,400,000.00
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	90,168.00
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(90,168.00)
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(90,168.00)

3. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төрийн захиргааны байгууллагын манлайллыг дээшлүүлж, төрийн албаны шинэчлэлийг гүнзгийрүүлж, хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, хөгжлийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлж дүгнэх, удирдлагыг цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын үйлчилгээ мэдээллээр хангах, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чанартай хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Төрийн албаны тухай хуульд - 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр, 05 дугаар сарын 04-ний өдөр, 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 11 дүгээр сарын 10-ны өдөр, 12 дугаар сарын 07-ны өдөр, 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр,
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн

тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нэгтгэл тайланд хамрагдсан байгууллагуудын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,431.5 сая төгрөгөөр буюу 19.6 хувиар өссөн байна.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,340.6	2,613.2	1,727.4
Авлага	976.6	666.5	310.1
Бараа материал	1,102.3	845.9	256.4
Үндсэн хөрөнгө	41,478.6	53,204.0	11,725.4
Нийт хөрөнгө	47,898.1	57,329.6	9,431.5
Өр төлбөр	103.7	920.0	816.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	47,794.4	56,409.6	8,615.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	47,898.1	57,329.6	9,431.5

Эх сурвалж: Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 2,613.2 сая төгрөг болж, өмнөх оноос 1,738.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+) Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Төрийн сангийн харилцах	4,321.4	2,613.1	1,708.3
Арилжааны банк дахь харилцах	19.1	41.1	22.0
Дүн	4,340.5	2,613.2	1,738.3

Эх сурвалж: Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлд Орон нутгийн ерөнхий орлогын 3,981.5 сая, Хоршоо хөгжүүлэх сангийн 252.6 сая, Барьцаа сангийн 12.1 сая, Орон нутгийн хөгжлийн сан 75.2 сая, нийт 4,321.4 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн

үлдэгдэл 14.5 сая, Улаангом тохижилт үйлчилгээ орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын 4.6 сая, нийт 19.1 сая төгрөг арилжааны банкин дахь харилцах дансны үлдэгдэлтэй байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 666.5 сая төгрөг болж 310.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Авлагын үлдэгдэл

<i>/сая төгрөг/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Хувь хүмүүсээс авах авлага	36.7	28.3	-8.4
Дансны авлага /ТӨҮГ/	133.8	1.2	-132.6
Байгууллагаас авах авлага	1.1	5.0	3.9
Зээлийн хүүгийн авлага	38.2	22.1	-16.1
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	3.5	3.5	0.0
Хувь хүмүүст олгосон зээлийн авлага	763.3	606.4	-156.9
Дүн	976.6	666.5	-310.1

Эх сурвалж: Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэлд Улаангом тохижилт үйлчилгээ орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын 12.7 сая, Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн авлага 632.0 сая, Засаг даргын Тамгын газрын авлага 17.5 сая, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын авлага 1.1 сая, Орон нутгийн хөгжлийн сангийн авлага 3.2 төгрөгийн авлагууд байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 774.3 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 1,102.3 сая төгрөг болж 328.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл

<i>/сая төгрөг/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Тусгай зориулалттай материал	0.5	0	-0.5
Эм боох материал	48.3	0	-48.3
Бичиг хэргийн материал	14.1	3.2	-10.9
Аж ахуйн материал	226.7	179.6	-47.1
Сэлбэг хэрэгсэл	0.9	6.8	5.9
Барилгын засварын материал	37.1	42.4	5.3
Түлш, шатах тослох материал	0.6	0.6	0
Хүнсний материал	0.2	0	-0.2
Бусад хангамжийн материал	618.9	455.8	-163.1
Биологийн хөрөнгө	43.7	46.1	2.4
Мал амьтад	111.3	111.3	0
Дүн	1,102.3	845.9	-256.4

Эх сурвалж: Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материал дансны үлдэгдэл 256.4 сая төгрөгөөр буурахад сумын Засаг даргын Тамгын газрын биологийн хөрөнгө, бусад хангамжийн материал, эм боох материал, аж ахуйн материал буурсантай нь голлон нөлөөлсөн байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 41,478.6 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 53,204.0 сая төгрөг болж 11,725.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Барилга, байгууламж, орон сууц	10,340.1	12,453.3	2,113.2
Хуримтлагдсан элэгдэл	-2,551.4	-2,769.0	-257.6
Авто-тээврийн хэрэгсэл	1,913.6	2,716.5	802.9
Хуримтлагдсан элэгдэл	-739.4	-931.9	-192.5
Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,133.9	1,423.1	289.2
Хуримтлагдсан элэгдэл	-617.1	-753.9	-136.8
Тавилга, аж ахуйн эд хогшил	260.0	329.6	69.6
Хуримтлагдсан элэгдэл	-116.2	-139.2	-23.0
Зам, гүүрийн байгууламж	31,915.9	10,056.1	-21,859.8
Хуримтлагдсан элэгдэл	-13,640.8	-1,546.7	132.1
Бусад үндсэн хөрөнгө	9,991.4	35,886.2	25,894.8
Хуримтлагдсан элэгдэл	-1,186.5	-8,104.4	-6,917.9
Дуусаагүй барилга, байгууламж	42.4	42.4	0
Ном	1.2	1.3	0.1
Программ хангамж	28.3	28.2	-0.1
Хуримтлагдсан элэгдэл	-11.1	-14.0	-2.9
Бусад биет бус хөрөнгө	4,714.3	4,526.4	-187.9
Дүн	41,478.6	53,204.0	11,725.4

Эх сурвалж: Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 53.204.0 сая төгрөг болж 11,725.4 сая төгрөгөөр өссөн нь авто тээврийн хэрэгсэл 802.9 сая, машин тоног төхөөрөмж 289.2 сая, тавилга, аж ахуйн эд хогшил 69.6 сая, зам, бусад үндсэн хөрөнгө 25,894.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 103.7 сая төгрөг болж 58.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Ажилчидтай холбогдсон өглөг	0.5	0.6	0.1
Байгууллагад төлөх өглөг	49.4	811.5	762.1
Хувь хүмүүст төлөх өглөг	0.2	6.3	-6.3
Дансны өглөг /ТӨҮГ/	41.5	38.3	-3.2
Бараа үйлчилгээний зардлын өглөг		38.6	-38.6

Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	12.1	24.7	12.6
Нийт дүн	103.7	920.0	726.7

Эх сурвалж: Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл 920.0 сая төгрөг болж 726.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Засаг даргын Тамгын газрын байгууллагад төлөх өглөг 84.2 сая, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагад төлөх өглөг 15.4 сая, Улаангом тохижилт үйлчилгээ орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын 38.3 сая, Баруун бүсийн хөгжлийн төв, сургууль, цэцэрлэгийн тогтмол зардлын өглөг 437.5 сая, бусад сангийн байгууллагад төлөх өглөг 24.7 сая төгрөгийн өглөг нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 47,794.4 сая төгрөг байснаас эцсийн үлдэгдэл 56,409.6 сая төгрөг болж 9,535.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7 Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Б	1	2.0	3=2-1
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	790.4	790.4	0
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	15,962.4	17,496.4	1,534.0
Хуримтлагдсан үр дүн	30,629.2	37,875.6	7,246.4
Өмнөх үеийн үр дүн	26,890.1	29,276.3	2,386.2
Тайлант үеийн үр дүн	3,739.1	8,599.3	4,860.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	412.4	247.1	-165.3
Дүн	47,794.4	57,329.6	9,535.2

Эх сурвалж: Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 57,329.6 сая төгрөг болж 9,535.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Тайлант онд татварын орлого 19,350.7 сая, татварын бус орлого 1,422.7 сая, нийт 20,773.4 сая төгрөгийн орлого орсон байна.

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчдын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2,112.5 сая төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 213.4 сая төгрөгийн 5 алдааг залруулж, 1,899.1 сая төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгсөн байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

Улаангом сумын Засаг даргын Тамгын газар:

Албан шаардлага

1. Улаангом сумын Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар 20.0 сая, Улаангом сумын Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/42 дугаар тушаалаар 20.0 сая, нийт 40.0 сая төгрөгийг өөрийн харьяаны бус байгууллага руу эрх шилжүүлсэн зөрчилд албан шаардлага өгсөн.
2. Багаж техник, хэрэгслийн зардлаас 49.7 сая, бусад хөрөнгийн зардлаас 61.6 сая, нийт 111.3 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэхдээ шууд худалдан авалт хийсэн зөрчилд албан шаардлага өгсөн.

3. Улаангом сумын Засаг даргын тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн батлагдсан орон тоонд байхгүй албан тушаалыг хавсруулахгүй байх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
4. Төсвийн хөрөнгөөр 30.3 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан зөрчилд албан шаардлага өгсөн.
5. Улаангом сумын Засаг даргын тамгын газрын бусад хөрөнгийн данснаас 60 айлын арын зогсоолын гүйцэтгэлд 61.8 сая, 6 засварын ажлын зураг төсвийн 41.3 сая, нийт 103.1 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын арга хэмжээнд зарцуулсан байна.

Төлбөрийн акт

1. Засаг даргын нөөц хөрөнгөнөөс иргэнд үзүүлсэн дэмжлэгийг давхардуулан Улаангом сумын Засаг даргын тамгын газрын нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 1.5 сая төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

Улаангом сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:

Зөвлөмж:

1. Улаангом сум нь 2024 онд шилдэг сумаар шалгарч Иргэдийн хурлын хурлын дарга болон ажлын албаны даргад 1.9 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг давхардуулан олгосон нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.5-д “Шагналыг байгууллагын, Засгийн газрын, төрийн дээд шагнал гэсэн дарааллаар олгоно. Мөнгөн шагнал, үнэ бүхий зүйл дурсгахаас бусад шагналыг төрийн албан хаагчид давхардуулан олгохгүй...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд зөвлөмж өгсөн.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд нийт 23,432.1 сая төгрөгийн санхүүжилт авахаас орон нутгийн төсвөөс 19,113.2 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих 2,816.2 сая, Хоршоо хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 252.7 сая, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлгээр 1,020.5 сая, Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүжүүлэх зээлийн эргэн төлөлтөөс 154.3 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тооцон төлөвлөж, Орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдлээс 75.2 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Улаангом сумын 2025 оны төсвийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 02/10 дугаар тогтоолоор санхүүжүүлэх эх үүсвэрийг 22,458.6 сая, нийт зардлыг 22,458.6 сая төгрөгөөр баталсныг 2025 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 05/01 дүгээр тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 973.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 23,432.1 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 19,500.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,015.8 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 236.5 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 21.1 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, 1,720.9 сая урьд оноос санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 22,494.3 сая төгрөг буюу 95.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 2.0 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 25.1 сая, нийт 27.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 26.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.6.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Золоо гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 43 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 243.8 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 51.811.6 сая төгрөгийн 1 хувь буюу 518.1 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 414.4 сая төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн нэгтгэсэн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 145 мэдээллээс хугацаандаа оруулсан 143, хугацаа хоцроож 3 мэдээлэл оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2024-2025 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Улаангом сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 1,899.1 сая төгрөгийн зөвлөмж өгснийг биелэлтийг 100% хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 8 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	1,899.1	1	1,899.1	100%
Нийт дүн	1	1,899.1	1	1,899.1	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн засвар, тохижилтын ажлыг хүлээн авахдаа зохиогчийн болон захиалагчийн хяналтыг Улаангом сумын дэд бүтэц хариуцсан мэргэжилтнээр ахлуулсан баг хийсэн байна. Дараагийн аудитаар хөрөнгө оруулалтаар хийгдэх зураг, төсөвтэй төсөл, арга хэмжээнд хийгдсэн зохиогчийн болон захиалагчийн хяналтын хэрэгжилтийг нягтлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Шууд худалдан авалт хийсэн	1	32.0					1	32.0		
Дүн										
Нийт дүн	1	32.0					1	32.0		

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/
 АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Г.БОЛОО



2026 оны 03 сарын 25-ны өдөр

